

# ХААН СОЁМБО АУДИТ ХХК



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймаг дахь Политехник коллежийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/35/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Хөвсгөл аймаг  
2022 он

Аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар  
Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatara@audit.gov.mn](mailto:erdenebaatara@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр  
Утас: 99089114 Цахим хаяг: [tegshdelgerb@audit.gov.mn](mailto:tegshdelgerb@audit.gov.mn)

Ахлах аудитор: Б.Давааням  
Утас: 92113932 Цахим хаяг: [davaanyamb@audit.gov.mn](mailto:davaanyamb@audit.gov.mn)

Хаан соёмбо аудит ХХК-ын захирал: Х.Диймаа  
Утас: 99065668 Цахим хаяг: [info@khaansoyomboaudit.mn](mailto:info@khaansoyomboaudit.mn)

Гүйцэтгэсэн аудитор: Н.Бадамханд  
Утас: 99042699 Цахим хаяг: [khaan.soyombo.audit@gmail.com](mailto:khaan.soyombo.audit@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1. АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ.....	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	12
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	12
3.2 Байгууллагын гадаад дотоод орчин.....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.5.1 Төсвийн төлөвлөлт.....	13
3.5.2 Төсвийн гүйцэтгэл.....	13
3.6.3 Нэмэлт төсөв.....	13
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	14
4.1 Ерөнхий зүйл.....	14
4.2 Материаллаг байдал.....	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
4.5.1 Завсрын аудитын талаар.....	15
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	15
5.1 Төлбөрийн акт.....	15
5.2 Албан шаардлага.....	15
5.3 Зөвлөмж.....	15
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	16

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120

Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn

2023.02.24 № 01/145  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ПОЛИТЕХНИК  
КОЛЛЕЖИЙН ЗАХИРАЛ Н.БААТАР-  
ОЧИР ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймаг дахь Политехник коллежийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймаг дахь Политехник коллежийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Урьд оны өр төлбөр 0.8 сая төгрөг, шүүхийн шийдвэрээр ажилтанд олгосон 13.8 сая төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлэхээр авлага үүсгэсэн, байгууллагаас авах 1.9 сая төгрөгийн нийт 16.5 сая төгрөгийн авлага үүсгэсэн байна.

### Аудитын гол асуудал

Тайлант онд хүнсний ногоо тариалах дадлагын 15 га газар, аялал жуулчлалын чиглэлийн 1 га газрын 204.8 сая төгрөгийн орлогод бүртгэж авсан.

### Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2022 онд 2 зорилтын хүрээнд 18 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж ажилласнаас 85.8 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>186,961,872.55</b>	<b>196,608,141.17</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	867,789.00	16,602,032.46
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	810,000.00	14,660,140.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	57,789.00	00.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	00.00	1,941,892.46
3351	Байгууллагаас авах авлага	00.00	1,941,892.46
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	4,800,000.00	00.00
<b>3471</b>	<b>Урьдчилгаа тооцоо</b>	4,800,000.00	00.00
34712	Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	4,800,000.00	00.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	181,294,083.55	180,006,108.71
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	00.00	957,481.00
35130	Эм боох материал	00.00	957,481.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	15,477,120.00	7,646,000.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	142,743,843.55	147,256,397.71
35410	Бичиг хэргийн материал	1,114,000.00	3,053,200.00
35420	Аж ахуйн материал	35,579,035.00	32,588,445.00
35430	Сэлбэг хэрэгсэл	370,000.00	190,000.00
35440	Түлш, шатах тослох материал	26.20	2,048,155.36
35450	Барилгын засварын материал	39,856,973.17	34,998,332.17
35460	Хүнсний материал	240,757.02	68,000.02
35470	Бусад хангамжийн материал	65,583,052.16	74,310,265.16
35600	Мал амьтад	23,073,120.00	24,146,230.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>5,499,487,843.59</b>	<b>5,415,628,285.86</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	5,499,487,843.59	5,415,628,285.86
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	3,786,063,843.59	3,496,988,285.86
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,694,372,469.00	3,694,372,469.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-383,302,904.68	-592,342,924.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	224,691,617.00	224,691,617.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-109,752,365.94	-124,889,633.22
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,082,165,530.18	1,093,235,530.18
39206	Хуримтлагдсан элэгдэл	-895,869,350.25	-948,609,831.17
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	138,408,804.44	138,408,804.44
39208	Хуримтлагдсан элэгдэл	-132,296,704.76	-133,409,296.25
39214	Бусад үндсэн хөрөнгө	161,683,646.90	164,828,646.90
39215	Хуримтлагдсан элэгдэл	-28,760,267.58	-55,502,466.30
39217	Ном	34,723,369.28	36,205,369.28
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	1,713,424,000.00	1,918,640,000.00
39301	Програм хангамж	15,750,000.00	16,166,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-15,750,000.00	-15,750,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	1,713,424,000.00	1,918,224,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>5,686,449,716.14</b>	<b>5,612,236,427.03</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>2,374,952.86</b>	<b>21,687,775.04</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	2,374,952.86	21,687,775.04
<b>413</b>	<b>Өглөг</b>	2,374,952.86	21,687,775.04
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	4,982,000.78
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	2,374,952.86	16,705,774.26
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>5,684,074,763.28</b>	<b>5,590,548,651.99</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	5,684,074,763.28	5,590,548,651.99
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,813,287,268.54	3,013,287,268.54
51101	Өмч: - төрийн	2,813,287,268.54	3,013,287,268.54
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	850,605,969.41	557,079,858.12

Политехник коллежийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

51210	Өмнөх үеийн үр дүн	850,605,969.41	850,605,969.41
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-293,526,111.29
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,020,181,525.33	2,020,181,525.33
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>5,686,449,716.14</b>	<b>5,612,236,427.03</b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>3,169,466,911.60</b>	<b>1,838,182,442.71</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,551,334,692.60</b>	<b>31,740,900.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	1,551,334,692.60	31,740,900.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,551,334,692.60	31,740,900.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	51,924,800.00	3,440,900.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	37,193,980.00	13,800,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,462,215,912.60	14,500,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,618,132,219.00</b>	<b>1,806,441,542.71</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,522,978,600.00	1,466,787,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,522,978,600.00	1,466,787,400.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	88,694,158.00	96,422,342.71
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	88,694,158.00	96,422,342.71
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	00.00	243,231,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	243,231,800.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	6,459,461.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	6,459,461.00	00.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,897,086,006.58</b>	<b>2,131,708,554.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,897,086,006.58</b>	<b>2,131,708,554.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,842,377,452.28	2,081,630,790.64
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,078,848,153.23	1,200,339,053.96
210101	Үндсэн цалин	749,652,232.02	800,599,549.89
210102	Нэмэгдэл	213,683,623.55	282,138,737.66
210103	Унаа хоолны хөнгөлөлт	39,960,755.60	41,283,265.28
210104	Урамшуулал	75,551,542.06	76,317,501.13
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	133,246,935.11	149,309,391.90
210201	Тэтгэврийн даатгал	93,100,185.28	105,745,923.45
210202	Тэтгэмжийн даатгал	10,233,945.20	10,902,429.06
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,187,156.10	8,712,897.44
210204	Ажилгүйдлийн даатгал	1,971,233.32	2,178,257.17
210205	Эрүүл мэндийн даатгал	19,754,415.21	21,769,884.78
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	207,091,049.36	230,655,187.48
210301	Гэрэл, цахилгаан	6,402,214.14	13,861,576.00
210302	Түлш, халаалт	199,382,585.22	215,055,111.48
210303	Цэвэр, бохир ус	1,306,250.00	1,738,500.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	37,032,490.17	56,796,580.84
210401	Бичиг хэрэг	5,380,751.50	4,747,050.00
210402	Тээвэр, шатахуун	6,505,769.42	6,550,370.84
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,013,020.00	4,128,840.00
210404	Ном, хэвлэл	00.00	305,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	459,280.00	2,301,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,650,237.00	12,931,849.00
210408	Бараа материал акталсны зардал	12,023,432.25	25,832,271.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	23,951,880.00	46,536,336.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,418,080.00	507,205.00
210502	Хоол, хүнс	22,533,800.00	45,137,186.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	891,945.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	45,883,279.00	14,718,825.00

Политехник коллежийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210601	Багаж, техник, хэрэгсэл	432,000.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	509,300.00
210604	Урсгал засвар	45,451,279.00	14,209,525.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>96,000.00</b>	<b>5,969,200.00</b>
210702	Дотоод албан томилолт	96,000.00	5,969,200.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>9,679,726.00</b>	<b>5,039,936.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,753,598.00	922,938.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	1,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,079,900.00	720,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	196,728.00	257,998.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	176,500.00	363,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	473,000.00	781,000.00
210807	Газрын төлбөр	00.00	495,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>306,547,939.41</b>	<b>372,266,279.46</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	101,055,781.06	67,493,721.73
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	205,492,158.35	304,772,557.73
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>54,708,554.30</b>	<b>50,077,763.36</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>41,570,700.00</b>	<b>42,805,300.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	31,578,800.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	8,559,900.00	39,427,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,432,000.00	3,377,800.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>13,137,854.30</b>	<b>5,387,029.74</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,137,854.30	5,387,029.74
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>00.00</b>	<b>782,026.48</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	782,026.48
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>00.00</b>	<b>1,103,407.14</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	1,103,407.14
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>1,272,380,905.02</u></b>	<b><u>-293,526,111.29</u></b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>1,272,380,905.02</u></b>	<b><u>-293,526,111.29</u></b>

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

/ төгрөгөөр /					
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	1,272,380,905.02	1,272,380,905.02
C08	<b>2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>2,813,287,268.54</b>	<b>2,020,181,525.33</b>	<b>850,605,969.41</b>	5,684,074,763.28
D01	<b>2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>2,813,287,268.54</b>	<b>2,020,181,525.33</b>	<b>850,605,969.41</b>	5,684,074,763.28
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>2,813,287,268.54</b>	<b>2,020,181,525.33</b>	<b>850,605,969.41</b>	5,684,074,763.28
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	200,000,000.00	00.00	00.00	200,000,000.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-293,526,111.29	-293,526,111.29
D09	<b>2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>3,013,287,268.54</b>	<b>2,020,181,525.33</b>	<b>557,079,858.12</b>	5,590,548,651.99

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,670,740,075.00</b>	<b>1,809,882,442.71</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>52,772,800.00</b>	<b>3,440,900.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	52,772,800.00	3,440,900.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	52,772,800.00	3,440,900.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	51,924,800.00	3,440,900.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	848,000.00	00.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,617,967,275.00</b>	<b>1,806,441,542.71</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,522,978,600.00	1,466,787,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,522,978,600.00	1,466,787,400.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	89,244,588.00	96,422,342.71
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	89,244,588.00	96,422,342.71
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	00.00	243,231,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	243,231,800.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	5,744,087.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	5,744,087.00	00.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,643,193,777.00</b>	<b>1,809,882,442.71</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,643,193,777.00</b>	<b>1,809,882,442.71</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,566,362,913.70</b>	<b>1,758,344,679.35</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,069,691,957.88	1,214,044,130.82
210101	Үндсэн цалин	742,506,036.67	811,915,838.37
210102	Нэмэгдэл	213,673,623.55	284,428,793.16
210103	Унаа хоолны хөнгөлөлт	39,960,755.60	41,381,999.48
210104	Урамшуулал	73,551,542.06	76,317,499.81
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	141,522,812.46	144,380,454.26
210201	Тэтгэврийн даатгал	99,194,264.61	100,816,984.85
210202	Тэтгэмжийн даатгал	10,791,807.20	10,902,429.51
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,633,445.72	8,712,897.40
210204	Ажилгүйдлийн даатгал	2,078,292.09	2,178,258.82
210205	Эрүүл мэндийн даатгал	20,825,002.84	21,769,883.68
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	207,091,049.36	217,594,049.00
210301	Гэрэл, цахилгаан	6,402,214.14	13,861,576.00
210302	Түлш, халаалт	199,382,585.22	201,993,973.00
210303	Цэвэр, бохир ус	1,306,250.00	1,738,500.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	15,591,847.00	23,068,069.00
210401	Бичиг хэрэг	3,615,750.00	3,669,200.00
210402	Тээвэр, шатахуун	5,059,048.00	5,765,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,951,330.00	4,128,840.00
210404	Ном, хэвлэл	00.00	2,520,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	459,280.00	2,801,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,506,439.00	4,183,329.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	29,908,760.00	50,453,827.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	620,960.00	1,464,686.00
210502	Хоол, хүнс	24,897,000.00	43,239,441.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,390,800.00	5,749,700.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	7,197,000.00	16,127,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	600,000.00	546,600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	7,660,500.00
210604	Урсгал засвар	6,597,000.00	7,920,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	192,500.00	5,969,200.00

Политехник коллежийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн  
тайлангийн аудитын тайлан

210702	Дотоод албан томилолт	192,500.00	5,969,200.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>6,480,320.00</b>	<b>5,547,936.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,554,192.00	922,938.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	1,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,079,900.00	720,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	196,728.00	349,998.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	176,500.00	363,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	473,000.00	1,197,000.00
210807	Газрын төлбөр	00.00	495,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>88,686,667.00</b>	<b>81,159,913.27</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	88,686,667.00	81,159,913.27
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>76,830,863.30</b>	<b>51,537,763.36</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>63,693,009.00</b>	<b>44,265,300.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	22,331,900.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	37,803,700.00	39,427,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,557,409.00	4,837,800.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>13,137,854.30</b>	<b>5,387,029.74</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,137,854.30	5,387,029.74
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>00.00</b>	<b>782,026.48</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	782,026.48
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>00.00</b>	<b>1,103,407.14</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	1,103,407.14
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>27,546,298.00</b>	<b>00.00</b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,466,787,400.00	1,470,228,300.00	3,440,900.00	100.23
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,466,787,400.00	1,470,228,300.00	3,440,900.00	100.23
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,426,132,100.00	1,424,185,970.26	-1,946,129.74	99.86
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,131,851,600.00	1,131,851,470.37	-129.63	100.00
210101	Үндсэн цалин	751,340,200.00	731,660,761.95	-	97.38
210102	Нэмэгдэл	262,811,900.00	282,491,209.13	19,679,309.13	107.49
210103	Унаа хоолны хөнгөлөлт	41,382,000.00	41,381,999.48	-0.52	100.00
210104	Урамшуулал	76,317,500.00	76,317,499.81	-0.19	100.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	141,481,500.00	141,480,555.89	-944.11	100.00
210201	Тэтгэврийн даатгал	98,828,100.00	98,828,074.36	-25.64	100.00

Политехник коллежийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн  
тайлангийн аудитын тайлан

210202	Тэтгэмжийн даатгал	10,663,300.00	10,674,682.52	11,382.52	100.11
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,530,700.00	8,530,699.84	-0.16	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,132,700.00	2,132,709.43	9.43	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	21,326,700.00	21,314,389.74	-12,310.26	99.94
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>24,012,300.00</b>	<b>22,076,569.00</b>	<b>-1,935,731.00</b>	<b>91.94</b>
210401	Бичиг хэрэг	2,394,500.00	2,677,700.00	283,200.00	111.83
210402	Тээвэр, шатахуун	4,900,000.00	5,765,000.00	865,000.00	117.65
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,210,400.00	4,128,840.00	-2,081,560.00	66.48
210404	Ном, хэвлэл	2,520,600.00	2,520,500.00	-100.00	100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,802,700.00	2,801,200.00	-1,001,500.00	73.66
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,184,100.00	4,183,329.00	-771.00	99.98
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>46,989,900.00</b>	<b>46,988,412.00</b>	<b>-1,488.00</b>	<b>100.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,465,400.00	1,464,686.00	-714.00	99.95
210502	Хоол, хүнс	39,998,600.00	39,998,026.00	-574.00	100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,525,900.00	5,525,700.00	-200.00	100.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>16,127,100.00</b>	<b>16,127,100.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	546,600.00	546,600.00	0.00	100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	7,660,500.00	7,660,500.00	0.00	100.00
210604	Урсгал засвар	7,920,000.00	7,920,000.00	0.00	100.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>5,970,000.00</b>	<b>5,969,200.00</b>	<b>-800.00</b>	<b>99.99</b>
210702	Дотоод албан томилолт	5,970,000.00	5,969,200.00	-800.00	99.99
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>4,632,000.00</b>	<b>4,624,998.00</b>	<b>-7,002.00</b>	<b>99.85</b>
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,500,000.00	1,500,000.00	0.00	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	720,000.00	720,000.00	0.00	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	350,000.00	349,998.00	-2.00	100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	370,000.00	363,000.00	-7,000.00	98.11
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,197,000.00	1,197,000.00	0.00	100.00
210807	Газрын төлбөр	495,000.00	495,000.00	0.00	100.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>55067700.00</b>	<b>55067665.00</b>	<b>-35.00</b>	<b>100.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	55,067,700.00	55,067,665.00	-35.00	100.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>40655300.00</b>	<b>40655300.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>40,655,300.00</b>	<b>40,655,300.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	39,427,500.00	39,427,500.00	0.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,227,800.00	1,227,800.00	0.00	100.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,466,787,400.00</b>	<b>1,470,228,300.00</b>	<b>3,440,900.00</b>	<b>100.23</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,466,787,400.00</b>	<b>1,466,787,400.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,466,787,400.00	1,466,787,400.00	0.00	100.00
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>00.00</b>	<b>3,440,900.00</b>	<b>3,440,900.00</b>	
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	3,440,900.00	3,440,900.00	

<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	73.00	73.00	0.00	100.00
620001	Удирдах ажилтан	03.00	03.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	51.00	51.00	0.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	19.00	19.00	0.00	100.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>96,422,342.71</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>96,422,342.71</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	91,708,935.57
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	56,832,132.00
210101	Үндсэн цалин	56,832,132.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	53,061.30
210201	Тэтгэврийн даатгал	53,061.30
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	3,351,641.00
210301	Гэрэл, цахилгаан	2,279,741.00
210302	Түлш, халаалт	384,400.00
210303	Цэвэр, бохир ус	687,500.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	991,500.00
210401	Бичиг хэрэг	991,500.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	3,465,415.00
210502	Хоол, хүнс	3,241,415.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	224,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	922,938.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	922,938.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	26092248.27
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	26,092,248.27
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	3610000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	3,610,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,610,000.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>1,103,407.14</b>
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	1,103,407.14
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	96,422,342.71
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	96,422,342.71
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	96,422,342.71

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хөвсгөл аймгийн “Политехник коллеж” нь Мэргэжлийн боловсрол, сургалтыг иргэний авьяас, сонирхол, хөдөлмөр эрхлэх хэрэгцээнд тулгуурлан боловсролын үндсэн зарчим, олон улсын нийтлэг жишиг, хандлагад нийцүүлэн мэргэжлийн ур чадвар, боловсрол эзэмшүүлэх, мэргэшлийг дээшлүүлэх, хөдөлмөрийн болон харилцааны соёл төлөвшүүлэх чиг үүрэгтэй байгууллага юм.

#### 3.2 Байгууллагын гадаад дотоод орчин

Байгууллагад мөрдөгдөх дараах хууль тогтоомжуудад тайлант онд өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

1. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 1 дүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн.
2. Төрийн бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах хяналт тавихад чиглэсэн “Төрийн хэмнэлтийн тухай” хууль хэрэгжиж эхэлсэн.
3. Төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор тогтоосон ба 2022 оны 192 дугаар тогтоолоор эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээг өөрчлөн тогтоосон байна.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймаг дахь Политехник коллежийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

#### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Политехник коллежийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 74.2 сая төгрөгөөр буюу 1.3 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өөрчлөлт
			3=2-1
Б	1	2	3=2-1
Дансны авлага	0.9	16.6	15.7
Бараа материал	181.3	180.0	(1.3)
Үндсэн хөрөнгө	5,499.5	5,415.6	(83.8)
Биет бус хөрөнгө	1,713.4	1,918.6	205.2
<b>Нийт хөрөнгө</b>	<b>5,686.4</b>	<b>5,612.2</b>	<b>(74.2)</b>
Дансны өглөг	2.4	21.7	19.3
-төрийн	2,813.3	3,013.3	200
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	2,020.2	2,020.2	-

Хуримтлагдсан үр дүн	850.6	557.1	(293.5)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>5,686.4</b>	<b>5,612.2</b>	<b>(74.2)</b>

Дансны авлага 15.7 сая төгрөгөөр өссөн байна. Үүнд:

- Шүүхийн шийдвэрээр ажилтанд олгосон 13.8 сая төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлэхээр авлага үүсгэсэн.
- Байгууллагаас авах 1.9 сая төгрөгийн авлага үүссэн байна.

Нийт өр төлбөр 19.3 сая төгрөгөөр өссөн байна. Үүнд:

- Цалинтай холбоотой нийгмийн даатгалын шимтгэлийн өр 4.9 сая төгрөг
- Бараа үйлчилгээний өр төлбөр 16.7 сая төгрөг байна.

Бараа материал 1.3 сая төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгө данс 83.8 сая төгрөгөөр буурсан байна.

Хуримтлагдсан үр дүн 307.4 сая төгрөгөөр багассан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,906.1 сая, нийт зарлагыг 2,144.2 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас урсгал зардлыг 677.4 сая төгрөгөөр бууруулж, 1,466.8 сая төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,466.8 сая төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлого 3.4 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,464.8 сая төгрөг буюу 99.8 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний зардал

/сая төгрөгөөр/

Хөтөлбөр, арга хэмжээ	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
<b>71804</b>	<b>Хөвсгөл аймаг дахь Политехник коллеж</b>	<b>1466.8</b>	<b>1464.8</b>	<b>(1.9)</b>	<b>99.9</b>
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	1386.2	1384.2	(1.9)	99.9
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж,	40.6	40.6	0	100
81806	Дотуур байрны хүүхдийн хоол	40.0	40.0	0	100

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагад нэмэлтээр 96.4 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. Үүнээс: Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалд 56.8 сая төгрөг, байр ашиглахтай холбоотой тогтмол зардалд 3.3 сая төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийхэд 26.0 сая төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 3.6 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажилд 0.9 сая төгрөг зарцуулсан.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Политехник коллежийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хаан Соёмбо Аудит ХХК-ийн чанарын хяналт, ахлах аудитор Н.Бадамханд гүйцэтгэж, хяналтыг анхан шатанд Хаан Соёмбо Аудит ХХК-ийн захирал Х.Диймаа, дараагийн шатны хяналтыг ахлах аудитор Б.Давааням, аудитын менежер Б.Тэгшдэлгэр, дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Политехник коллежийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 37.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 буюу 26.1 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага Тэргүүн дэд, дэд, орлогч дарга, тээврийн хэрэгсэл, албан тасалгаа, дүрэмт хувцас, албан томилот, нэг удаагийн мөнгөн тэтгэмж, бусад хангамж, цахим худалдан авалт, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглосон зарим асуудал, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд зөрчилтэй зүйл илрээгүй болно.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Байгууллагын 2022 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 2022 онд цалингаас бусад 5 саяаас дээш үнийн дүн бүхий 125.0 сая төгрөгийн 13 гүйлгээг мэдэллээгүй байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Хөвсгөл аймгийн Политехник коллежид завсрын аудит хийгээгүй.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар нийт үндсэн хөрөнгө, эргэлтийн хөрөнгө, орлогын зарлагын данс, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 160.7 сая төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага, 5.3 сая төгрөгийн 2 зөрчилд 2 зөвлөмж өгсөн байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	160.7	0	0	0
Зөвлөмж	2	5.3	2	5.3	100
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>166.0</b>	<b>2</b>	<b>5.3</b>	<b>66.6</b>

/сая төгрөгөөр/

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар онцгойлон үзэх асуудал байхгүй байна.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 200.0 сая төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 200.0 сая төгрөгийн алдааг залруулсан.

Үүнд: Эзэмшлээр байгаа газрыг орлогод авахдаа 200.0 сая төгрөгөөр засгийн газрын санг нэмэгдүүлэхгүйгээр үндсэн үйл ажиллагааны орлогыг кредитэлсэн нь УСНББОУС-17, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаал болон НБББББ-тэй нийцэхгүй байна.

Аудитаар нийт 184.2 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 182 сая төгрөгийн 5 зөвлөмж өгсөн.

#### 5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй.

#### 5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөөгүй болно.

#### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

##### 1.1. Илрүүлэлт:

Шилэн дансны цахим хуудсанд 125.0 сая төгрөгийн 13 мэдээллийг дутуу мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-ийг зөрчсөн байна.

##### 1.2. Өгсөн зөвлөмж: Шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллийг хугацаанд нь үнэн зөв мэдээлж байх

#### 2. Балансын данстай холбоотой асуудал

##### 2.1. Илрүүлэлт:

Урьд оны өр төлбөр 0.8 сая төгрөг, шүүхийн шийдвэрээр ажилтанд олгосон 13.8 сая төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлэхээр авлага үүсгэсэн, байгууллагаас

авах 1.9 сая төгрөгийн авлага үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6.4.8 заалтыг зөрчсөн байна. Энэ нь "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Авлагыг барагдуулж цаашид нэмж авлага үүсгэхгүй байх.

**3. Балансын данстай холбоотой асуудал**

3.1. Илрүүлэлт:

Цалинтай холбоотой нийгмийн даатгалын шимтгэлийн өр 4.9 сая төгрөг, бараа үйлчилгээний өр төлбөр 16.7 сая төгрөгийн өглөг үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6.4.8 заалтыг зөрчсөн байна. Энэ нь "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Өр төлбөрийг барагдуулж цаашид нэмж үүсгэхгүй байхад анхаарч ажиллах.

**4. Балансын данстай холбоотой асуудал**

4.1. Илрүүлэлт:

Халаалтын зардлаас 1.3 сая төгрөгөөр шатахуун авч зарцуулсан нь Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан зардлын эдийн засгийн ангилал зөрчиж гүйлгээ хийсэн.

4.2. Өгсөн зөвлөмж:

Зардлыг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулах.

**5. Хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

5.1. Илрүүлэлт:

И-баримтгүйгээр 18.1 сая төгрөгийн худалдан авалт хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь заалттай нийцэхгүй байна.

5.2. Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримтын бүрдлийн иж бүрэн байдлыг хангаж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/сая төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	Залруулаагүй	Тоо	Дүн	Тоо	Дүн
Эзэмшлээр байгаа газрыг орлогод авахдаа засгийн газрын санг нэмэгдүүлэхгүйгээр үндсэн үйл ажиллагааны орлогыг кредитэлсэн	1	200.0					1	200.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/сая төгрөгөөр/ Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Авлага үүсгэсэн	1	16.6					1	16.6				
Өр төлбөр үүсгэсэн	1	21.7					1	21.7				
Эдийн засгийн ангилал зөрчиж гүйлгээ хийсэн	1	1.3					1	1.3				
И-баримтгүйгээр худалдан авалт хийсэн	1	18.1					1	18.1				
Дүн	4	57.7	1	1.5			4	57.7				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/сая төгрөгөөр/ Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Мэдээллээгүй	13	125.0					1	125.0

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

БАТАЛГААЖУУЛСАН:

ХААН СОЁМБО АУДИТ ХХК-ИЙН

ЗАХИРАЛ

ЧАНАРЫН ХЯНАЛТ, АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

Б.ДАВААНЫМ ОГНОО:

Х.ДИЙМАА

Н.БАДАМХАНД

